

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ
02 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшингээр ахлуулсан Шуурхай бүлгийн бүрэлдэхүүн Хөвсгөл аймагт 2020 оны 02 дугаар сарын 13-наас 14-ний өдрүүдэд ажиллаж өвөлжилтийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцан, тулгамдсан асуудлуудыг шийдэж ажиллаа.

Хөвсгөл аймаг 2020 оныг "Зүтгэл-Итгэл-Санаачилга"-ыг дэмжих жил болгон зарласан. Нэрлэсэн жилийн ажлыг эрчимжүүлэх, төрийн албан хаагчид, иргэд нийтийн оролцоог хангах зорилгоор нэрлэсэн жилийн тугийг төрийн байгууллага, сумдад ажлын 7 хоногийн хугацаатай хуваарийн дагуу өртөөчлөн аялуулах ажлыг эхлүүллээ.

Туг аялах явцад сумд, агентлаг, байгууллагууд нэрлэсэн жилийн захирамжийн хэрэгжилтийг хангах, зохион байгуулагдаж байгаа болзолт уралдаануудыг иргэдэд хүргэх, инноваци шингэсэн бүтээлч ажил санаачилж, үр дүнг олон нийтэд мэдээллэх, тугийг хуваарийн дагуу дараагийн байгууллага, суманд шилжүүлэх, ажлын тайланг гаргах зэрэг ажлуудыг хэрэгжүүлэх юм байна.

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн хөтөч” үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааг иргэдэд сурталчилан таниулах зорилгоор “Эрх чөлөө” сонинтой хамтран ажиллах гэрээг байгуулж 8 нүүр сонины материалыг бэлтгэн 30000 ширхэг хэвлүүлж 23 сум 1 тосгонд хуваарилан иргэдэд хүргэж ажиллалаа.

Мөн үйл ажиллагааны хөтөлбөрийн тайлан 3 нэвтрүүлгийг бэлтгэн иргэдэд хүргэж ажилласан байна.

Коронавирусаас урьдчилан сэргийлэх, өвөлжилт хүндэсрэн сумдын малчдад туслах зорилгоор аймгийн хэмжээнд итгэл сэтгэл аян хэрэгжиж төрийн болон төрийн бус байгууллагууд аймгийн онцгой комисст сэтгэлийн дэм хандив өгч байна.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:

Төрийн сангийн төлбөр тооцооны программаар 2020 оны 02-р сард 46 Төсөвт байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас 9.2 тэрбум төгрөгний 1.873 ширхэг гүйлгээ шивэгдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн 2020 оны сарын мэдээгээр Орон нутгийн орлого, санхүүжилт 9,829.0 сая төгрөгний төлөвлөгөөтэйгээс 9,285.7 сая төгрөг буюу 94.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарлагын гүйцэтгэл батлагдсан төсөв 9,763.1 сая төгрөг байгаа бөгөөд үүнээс 65,0 мянган төгрөг нь тусгай зориулалтын шилжүүлгээс, 2,433.0 сая төгрөг нь орон нутгийн байгууллагуудад олгох санхүү дэмжлэг болон аймаг сумын орлогоос тус тус санхүүжигдсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээнд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 9,763.1 сая төгрөг, зарлагын гүйцэтгэл 6,860.3 мянган төгрөг буюу 70.3 хувьтай байна. ТЗШ-ын санхүүжилт болон санхүүгийн дэмжлэг бүрэн ирсэн. ОНХС-ийн санхүүжилт дутуу ирсэн. Үндсэн үйл ажиллагааны орлого өндөр давалттай байна..

Төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Төсвийн нийт авлага 1.802,7 сая төгрөг өмнөх сараас 3.412,2 сая төгрөгөөр буурсан байна.

Нийт өглөг 310.0 сая төгрөг өмнөх сараас 635.9 сая төгрөгөөр буурсан байна.

Нийгмийн даатгалын хэлтэсийн сарын шуурхай мэдээ:

2020 оны 02 сарын байдлаар нийгмийн даатгалын санд шимтгэлийн орлого 1792.3 сая төгрөг, сайн дурын даатгуулагчаас 170.1 сая төгрөгийн шимтгэлийн орлого, 98.1 хувиар биелүүлсэн байна.

Төлөвлөгөөг сан тус бүрээр нь харуулбал:

/Сая.төг/

Төрөл	төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь
Тэтгэвэр	3426.7	3169.7	92.5
Тэтгэмж	294	355.1	120.8
Үомшө	186.9	281.4	150.6
ЭМД	0,0	0,0	0,0
Ажилгүйдэл	50.1	75.9	151.5
дүн	3957.7	3882.1	98.1

Тэтгэврийн даатгалын сангаас 19194 тэтгэвэр авагчид 13339.3 сая төгрөгийн 4 төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас 593 даатгуулагчдад 463.1 сая төгрөгийн тэтгэмжийн зардал, ажилгүйдлийн даатгалын сангаас 47 даатгуулагчдад 102.4 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 305.4 сая төгрөг байна.

Санхүү хяналт дотоод аудитын алба нь:

2020 оны төлөвлөгөөний дагуу нийт 1 суманд 6 төрлийн нийцлийн аудит 1 санхүүгийн хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн. Дотоод хяналтын чиглэлээр нийт 12 албан хаагчид зөвөлгөө өгч ажилласан.

Байгууллагын хүрээнд 2020 онд авч хэрэгжүүлэх “Зүтгэл итгэл санаачилга” нэрлэсэн жилийн төлөвлөгөө, ёс зүйн хороо, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, “Хүүхдэд ээлтэй нутаг тогтвортой байдал” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, Жендэрийн эрх тэгш байдал, дотоод хяналтын дэд төлөвлөгөө боловсруулан түүнийхээ биелэлтийг ханган ажиллаж байна.

Дотоод аудитын явцад 14 танилцуулга, тайлан бичиж, төлүүлэх 32 акт тогтоон, зөрчил арилгуулах 7 албан шаардлага тавьж ажиллав. Байгууллагын хэмжээнд 2020 оны 2 дугаар сарын 21 ний байдлаар 52 албан бичиг хүлээн авч, 17 хариутай балбан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлж 64 албан бичгийг холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаж байна. Оны эхнээс манай байгууллагад хандсан өргөдөл, гомдол ирээгүй байна.

Гурав. Хууль эрхзүйн бодлогын хүрээнд :

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Судлагдахуун бүрээр үнэлгээ арга зүйн баг байгуулж, цахим хичээл даалгаврыг бэлтгэн СӨБ, ЕБС-д хүргүүлсэний зэрэгцээ, Google form ашиглан төгсөх ангийн сурагчдын ЭШ-ын 2006,2016,2017 оны бүх хувилбаруудыг цахим хэлбэрт орууллаа.

Аймгийн хэмжээний эрсдэлт нөхцөлд байгаа СӨБ, ЕБС-сурагчдын судалгааг нэгтгэж мэдээллийн сан үүсгэсэн.

Соёлын үйлдвэрлэлийн бодлогыг хэрэгжүүлэх үндэсний чадавхийг бэхжүүлэх төслийн сургалтын мэдээллийг аймгийн болон БСУГазрын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэлээ.

Монгол хэл, бичиг, уран зохиолын багш нарын мэргэжлийн онолын чиглэлээр жишиг даалгавар, Монгол хэл, бичиг, уран зохиолын хичээлийн цогц хэрэглэгдэхүүн боловсруулж багш бүрд зөвлөмж өгч ажиллалаа.

6,7,8,10,11-р ангийн монгол хэл, бичиг, уран зохиолын хичээлийн анги дэвших шалгалтын жишиг даалгавар боловсруулан, сурагчдын гарт хүргэж үйл ажиллагаа зохион байгууллаа.

ЭЕШ-ын бүртгэл 2020 оны 2-р сарын 15-нд орон даяар эхлэн бүртгүүлэгчдэд хяналт тавин ажиллаж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр

-Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх, 33 дугаар зүйлийн 33.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 10 дугаар зарлиг, Засгийн Газрын 2020 оны 62 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 04 дүгээр, Эрүүл мэндийн сайдын 93 дугаар тушаалыг хэрэгжүүлэх хүрээнд ЭМГ-ын даргын Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлэх тухай А/16 дугаар тушаалыг боловсруулан гаргаж, бүх ЭМБ-уудад хүргүүлсэн ба тус тушаалаар өндөржүүлсэн бэлэн байдлын үед Эрүүл мэндийн байгууллагуудын ажиллах удирдамжийг гаргасан. Мөн шинэ корона вирусын халдварын болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах тухай Эрүүл мэндийн газрын даргын А/06 дугаар тушаал батлагдан гарч бэлэн байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсан байна. Уг тушаалтай холбогдуулан нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл бусад зүйлс, авто тээвэр, нисэх буудал, Ханх хилийн гаальд хэрэглэгдэх халдваргүйтгэл, хувийн хамгаалах хувцас хэрэгслийн тооцоо судалгааг гарган Аймгийн онцгой комиссын хурлаар хэлэлцүүлж 5.674.900 төгрөгийг шийдүүлэн хувцас хэрэгслийг эрүүл мэндийн байгууллагуудад хувиарлан өгсөн байна. Мөн улсын онцгой комисст санал болгох эм эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис хамгаалах хувцас хэрэгслийн тооцоог хийж Аймгийн онцгой байдлын газарт хүргүүлсэн.

-Корона вирусийн эрсдлээс сэргийлэх бэлэн байдлыг хангах зохион байгуулалт, эмчилгээ оношлогооны зөвлөмжүүдийг Эрүүл мэндийн газрын даргын албан бичгээр Эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн ба корона вирустэй холбоотой мэдээлэл өгөх цаг, эх сурвалж нь тодорхойгүй мэдээ мэдээллийг түгээхгүй байх талаарх албан бичгийг Хэвлэл мэдээллийн байгууллагуудын дарга нарт хүргүүлсэн.

-Корона вирусийн халдварын тандалтын эмнэлэгт суурилсан тандалтын мэдээг өдөр бүр 23 сумаас авч нэгтгэн холбогдох мэргэжилтнүүдийг мэдээллээр ханган ажиллаж байгаа ба эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй иргэдийн 30 хувь нь амьсгалын замын цочмог, хүнд халдвар, томуу томуу төст өвчнөөр өвчилж байгаатай холбогдуулан иргэд олон нийтийн газраар үйлчлүүлэхдээ маск зүүж байгаа эсэхэд тандалт хийж нийт 9 газраар орж үнэлгээ хийсэн байна. Уг үнэлгээгээр нийт иргэдийн 39,6 хувь нь маск зүүхгүй байгааг анхааруулж ажиллаа.

3. Цагаан сарын баярын амралтын өдрүүдэд Эрүүл мэндийн газрын 9 мэргэжилтэн 3 өдөр хариуцлагатай жижүүр хийж, эрүүл мэндийн байгууллагуудаас мэдээг авч нэгтгэн, Эрүүл мэндийн хөгжлийн төвд цахим хаягаар өгсөн ба энэ өдрүүдэд нийт 243 дуудлага хүлээн авсанаас насанд хүрэгчдийн 140, хүүхдийн 84,

осол гэмтлийн 19 дуудлага хүлээн авч үйлчилсэн ба яаралтай тусламжийн тасаг, нэгжээр 287 хүн үйлчлүүлж, тусламж үйлчилгээ авсан байна.

4. Хөвсгөл аймагт үйл ажиллагаа явуулж буй Эм ханган нийлүүлэх байгууллага, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаас корона вирусийн тархалттай холбогдуулан спирт денутрат, гар ариутгагч, амны хаалтын нөөцийн судалгаа, бэлэн байдлыг хангасан байдлын мэдээг өдөр тутам авч ажиллаж байна. Мөн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад бэлэн байдал, эмчилгээний нөөцийн судалгааг гаргаж ШУН-д өгсөн. Хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээ үзүүлэх Эрүүл мэндийн байгууллага бүр бэлэн байдлыг өөрсдийн нөөц боломжоор хангаж тусгаарлах өрөөг бэлтгэсэн.

5. Осол гэмтлийн үндэсний хөтөлбөрийн 2020-2022 оны аймгийн төлөвлөгөөнд тусгах саналыг салбар байгууллагуудаас авахаар Эрүүл мэндийн газрын даргын албан бичгийн Аймгийн Цагдаагийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Боловсрол соёл урлагын газар, Мөрөн сумын засаг дарга нарт хүргүүлэн ажилласан.

6. Аймгийн эрүүл мэндийн газарт 2020 оны 2 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 24 цагийн онцгой байдлын шуурхай штабыг байгуулан ажиллаж байна. Дээрх хугацаанд аймгийн Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Зооноз өвчин судлалын төв, Нэгдсэн эмнэлэг, Мөрөн сумын Засаг даргын тамгын газрын нийт 69 албан хаагч жижүүрлэн ажиллаа. Мөн хот хоорондын шалган нэвтрүүлэх постонд дээрх байгууллагуудын хамтарсан жижүүр гарч тус постоор нэвтэрч буй иргэдийн халууныг хэмжих, короны вирусээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмжийг өгч хяналт тавин ажиллаа.

Нийгмийн халамжийн 3 төрлийн үйлчилгээг 349 иргэнд үзүүлж орон нутгийн төсвөөс 64,5 сая төгрөгийг, 13 төрлийн үйлчилгээг 32,1 мянган иргэнд үзүүлж 3,3 тэрбум төгрөгийг улсын төсвөөс олгосон байна.

-Аймгийн Онцгой комиссын шийдвэрийн дагуу Мөрөн сумын 7 дугар багт байрлах “Ахмадын амралт, сувилал”-ын газрыг бэлэн байдалд шилжүүлэн холбогдох арга хэмжээг авсан.

-Нийгмийн халамжийн 4 төрлийн үйлчилгээг ebarimt-т холбоотой дансаар олгож эхэлсэн.

-Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг иргэний нэрийн данстай холбох ажлыг эхлүүлсэн.

Хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд:

Ажилд зуучлагдсан иргэний тоо: 39 иргэн ажилд зуучлагдан орсон байна. Идэвхтэй ажил хайгчдын тоо: 687 иргэн идэвхитэй ажил хайгчаар бүртгэгдсэн байна. Шинээр

бий болсон ажлын байрны тоо: Шинээр 171 ажлын байр бүртгэгдсэн байна. Үүнээс: Байнгын- 99, Улиралын-29, Түр-43.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр:

Нэг цэгийн үйлчилгээний төв:

-ГБХЗХГ-ын дэргэдэх “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д нийт 77 хүн үйлчлүүлсэн. Үүнээс хүүхэд 14 эмэгтэй 8 эрэгтэй 6 насанд хүрэгч 63 эрэгтэй 6 эмэгтэй 57 үйлчлүүлэгч нар тус тус үйлчлүүлсэн байна.

Аюулгүй байдлын хамгаалалт, түр хамгаалах үйлчилгээг нийт 7 хүнд үзүүлэв.

Сэтгэл зүйн үйлчилгээг 23 хүнд үзүүлэв.

Эрх зүйн туслалцаа үйлчилгээг нийт 24 хүнд үзүүлэв.

Холбон зуучлах үйлчилгээг нийт 3 удаа үзүүлсэн байна.

Эрүүл мэндийн үйлчилгээг 18 хүнд үзүүлэв.

-Газрын дэргэд хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийг 13 хүний бүрэлдэхүүнтэй байгууллагын даргын 2020 оны А/15 тушаалаар байгуулж, 24 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөн, онцгой нөхцөл байдлын үед нэг цэгийн үйлчилгээний төвийг бэлэн байдалд шилжүүлж, шаардлагатай нөөц бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна

-Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд 2020 оны 2 дугаар сард нийт 13 дуудлага мэдээлэл ирсэн Дуудлага тус бүрийг харьяа хамтарсан багт тухай бүр шилжүүлж, хяналтандаа авч 3 дуудлагын бүрэн шийдвэрлэж, бусад дуудлагыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

-Мөрөн сумын эрсдэлт нөхцөлт байгаа 30 өрхөд эргэлт, хяналтын ажлыг зохион байгуулав. Томуугийн тархалт ихсэх, шинэ төрлийн Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлж хөл хорио тогтоосонтой холбогдуулан эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, мэдээ мэдээллээр хангах, зорилтот бүлгийн хүүхдүүдийн эргэлт, хяналт хийх ажлыг 2 ажлын хэсэг гарч, аймгийн Онцгой байдлын газартай хамтран 2020 оны 2 дугаар сарын 5-6-ны өдрүүдэд зохион байгууллаа.

-2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 41 дүгээр бичгээр Онцгой комиссын албан даалгаврын 1.5, 10.4 дэх хэсгүүдэд заасан 0-5 настай хүүхэдтэй эцэг, эхчүүдийн ажлын цагт зохицуулалт хийж дэмжлэг үзүүлэх чиглэлийн хэрэгжилтийг

хэрхэн хангаж байгаа талаарх мэдээллийг сум, агентлаг, байгууллага, сургууль, цэцэрлэгүүдээс авсан.

Аймгийн хэмжээнд:

- Албан ёсны тушаал гарч богиносгосон цагаар ажиллаж байгаа 0-5 настай хүүхэдтэй албан хаагч- 1205
- Орон гэртээ хараа хяналтгүй, харгалзах хүнгүй үлддэг хүүхэдтэй өрх- 304
- Тэдгээр өрхүүдэд байгаа хүүхдийн тоо- 377
- Амьсгалын замын цочмог халдвар, томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн 5 хүртэлх насны хүүхдээ эмнэлэгт, эсвэл гэрээр асарч байгаа, 5 хүртэлх хоногийн цалинтай чөлөө авсан албан хаагч- 134
- Тэдгээр өрхүүдэд байгаа хүүхдийн тоо- 214 тус тус байна.

-Хяналт шалгалтыг хийв.

Шинэ төрлийн коронавирус дэгдэх өндөр эрсдэлтэй байгаатай холбогдуулан цагаан сарыг цахимаар тэмдэглэх уриалгыг дэмжиж, мөн урьдчилан сэргийлэх чиглэлд 6 төрлийн зөвлөмж, уриалгыг гарган цаасан хэлбэрээр нийт 750 ширхэгийг түгээн ажилласан байна. Мөн телевиз, радиотой хамтран хүүхдэд тавих хараа хяналтыг сайжруулах чиглэлээр иргэдэд мэдээлэл өгч ажиллаж байна. Хамтран ажиллах чиглэлээр “Түмний телевиз”, “Далай ээж телевиз”, гэр бүлийн радио 104.5-д албан бичиг хүргүүлэн, хүүхдийн эрх хамгаалал, хүүхдийн тусламжийн утас 108, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх 3 төрлийн шторкийг тодорхой үе автамжтайгаар иргэдэд хүргэн ажиллаж байна.

Мөрөн сумын 350 өрхөд гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийв. Томуугийн тархалт ихсэх, шинэ төрлийн Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлж хөл хорио тогтоосонтой холбогдуулан эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, мэдээ мэдээллээр хангах, зорилтот бүлгийн хүүхдүүдийн эргэлт, хяналт хийх ажлыг зохион байгуулав. Эргэлт, хяналтад Мөрөн сумын зорилтот 350 өрхөд гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийн, 2 төрлийн брошур, томуу томуу ТӨСТ өвчнөөс урьдчилан сэргийлэхэд өрх бүрт 1кг аарц тараан ажиллав.

Аймгийн Засаг даргын санаачилгаар 2020 оны аливаа болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн болон нийгмийн бусад орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хараа хяналтыг сайжруулах, салбар, байгууллага хоорондын

хамтын ажиллагааг эрчимжүүлж, эцэг эхчүүд, төрийн албан хаагчдын нийгмийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор хүүхдийн аюулгүй байдлыг хангах, Гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх “Хүүхэд- итгэлийн харц” аяныг 2020 оны 2 дугаар сарын 20-оос 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл өрнүүлж эхэллээ.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:

Мал хорогдлын мэдээ, өвөлжилтийн цаг үеийн мэдээллийг /23 сум 1 тосгон/ авч мэдээлэлийн нэгтгэж ажиллаа.Үүнд: Аймгийн хэмжээнд 24 суманд Адуу-2106, үхэр-3850, хонь-26776. Ямаа-26297 нийт 59029 толгой мал хорогдсон. Үүнээс: бод-5956, бог-53073 толгой малын зүй бусын хорогдол гарсан байна.

Аймгийн Засаг даргын 2020.02.24-ны өдрийн А/117 тоот захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд өвөлжилт хүндэрсэн Жаргалант, Галт сумдад “Зудын эрсдэлийн тойм судалгаа хийх ажлын хэсэгт Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга, аймгийн онцгой комиссын гишүүн Ч.Дашбаяраар ахлуулан ОБГ-ын гамшгийн эрсдэлийн удирдлагын үнэлгээ хариуцсан дэслэгч Ж.Дэлгэрмөрөн, гамшгаас хамгаалах хяналтын улсын байцаагч хошууч Л.Бямбасүрэн, Эрчим хүч ХХК-ны жолооч Л.Лхагвасүрэн, ХХААГ-ын мэргэжилтэн Б.Бэлэгдэмбэрэл нарын бүрэлдэхүүнтэй 02.04-02.26-ны хүртэлх хугацаанд ажилласан.

Зургаа.Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:

Цагдаагийн газраас ирүүлсэн шинжээч томилж шинжээчийн дүгнэлт гаргуулах тогтоолын дагуу Арбулаг суманд агнасан Халиун буга, Түнэл суманд агнадсан Шилүүсийн хэрэг, Хөвсгөл нуураас хууль бусаар загас барьсан хэрэгт тус тус шинжээчийн дүгнэлт гаргаж аймгийн Цагдаагийн газарт хүргүүлсэн.

Дэлгэрмөрөн голын сав газрын менежмент хариуцагч Номадик женис ХХК-ны загас агнуурын менежментийн төлөвлөгөөнд үнэлгээ дүгнэлт хийж зөвлөмж хүргүүлсэн.

Аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахтай холбогдуулан “Монгол гэр ажиллуулах журам”-ын төсөл боловсрууллаа. Аймгийн төвийн томоохон буюу 11-100, 100 аас дээш квт-ын хүчин чадалтай зуухны судалгааг нарийвчлан гаргах удирдамжийн дагуу БОАЖГ, УЦУОШТ, Мөрөн сумын ЗДТГ-аас бүрдсэн ажлын хэсэг уурын болон усан халаалтын зуухны судалгаа гаргах, зөвлөн туслах ажлаар 2 өдөр ажиллаж, 15 байгууллагаар орж, судалгааг гаргав. Уг судалгааг Орчны бохирдлын үндэсний хороонд хүргүүлэв.

Уг судалгааны үндсэн дээр Үндэсний хорооноос төрийн өмчийн байгууллагуудын зууханд утаа шүүгч тавих талаар төсөв хөрөнгө шийдэгдэх боломж байгаа юм.

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны мэргэжилтэн, инженер техникийн ажилтнууд аймагт ажиллаж, Дулааны станцад утаа шүүгч уутат фильтр тавих зорилгоор урьдчилан хэмжилт хийж, мэдээллийг цуглуулж авах ажил хийгдлээ. Уг хэмжилтийн дагуу БНХАУ-ын үйлдвэрт шууд захиалж хийлгэн, авч ирж угсрах ажил хийгдэнэ.

Хоггүй цэвэрхэн Монгол аяны хүрээнд сумдын дунд зарласан уралдааны удирдамжийн дагуу сумдыг идэвхжүүлэх, байгаль хамгаалагчдаар дамжуулан зөвлөмж өгөх ажлыг хийж, иргэд ихээр очдог уул овоонд байршуулах самбар, уриалгын загварыг гаргаж, сумдад өгсөн. Мөн цахимаар уриалга олон нийтэд хүргэж, 10000 гаруй иргэдэд хүрсэн байна.

Дэд бүтцийн салбар:

Мөрөн суманд шинээр 5 автобус нийтийн тээврийн үйлчилгээнд нийлүүлж Мөрөн сумын нутаг дэвсгэрт нийтийн зорчигч үйлчилгээг эрхлэх журмын төсөл боловсруулан Засаг даргын зөвөлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлууллаа.

2020 онд Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний ажлын болон зургийн даалгавар боловсруулан орон нутгийн өмчийн газар хүргүүлэн ажилласан байна.

Мөрөн суман дахь төсөвт байгууллага, аж ахуйн нэгжүүдэд дулааны эрчим хүч, цахилгаан эрчим хүч, цэвэр бохир ус нийлүүлэх ажлын гэрээ байгууллаа.

Аймгийн Засаг даргын “Мөсөн замын тээвэрлэлтийг хориглох тухай” захирамжийн хэрэгжилтийг ханган 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн мөсөн замаар авто тээврийн хэрэгслээр зорчих тээвэрлэлтийн үйл ажиллагааг зогсоолоо.

Долоо. Цаг үеийн бусад мэдээлэл:

Засгийн газрын 2020 оны 30 дугаар тогтоолын дагуу төрийн байгууллагууд нийт албан хаагчдын 0-5 насны хүүхдүүдийн судалгааг гарган ажлын цагийн зохицуулалт хийж хүүхдүүдээ асран хамгаалах боломжоор ханган ажиллаж байна.

Шинэ Коронавирусын халдвар болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Аймгийн хэмжээнд согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээний газруудын үйл ажиллагааг 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл зогсоох шийдвэр гарч, аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/66 дугаар захирамжийн хүрээнд Мөрөн суманд үйл ажиллагаа явуулж буй архи согтууруулах ундаагаар үйлчилдэг үйлчилгээний газруудад хяналт шалгалт хийх хуваарийн дагуу “Цагаан-Уул” хүнсний

зах, “Далай-Ээж” хүнсний зах, “Хөвсгөл-Эх”, “Гэгээ”, “Дөрвөн-Уул” барааны зах, “Шинэс” модон материалын зах, “Баян нуур” авто сэлбэгийн зах, Түүхий эд”-ийн зах, “Шинэ Мөрөн” ХҮТ-ийн үйл ажиллагаанд өдөр бүр хяналтын ажлыг холбогдох мэргэжлийн байгуулагатай хамтран зохион байгуулан ажиллаж тухайн аж ахуйн нэгж байгууллагын зөрчил дутагдалыг тухай бүрт арилгуулах, заавар, зөвлөмж өгөн ажиллаж байна.

Худалдааны газруудад амны хаалтгүй иргэнд үйлчлэхгүй байх, амны хаалтаа зүүхийг шаардах, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол чанартай хийх, гадуур онцын шаардлагагүй нөхцөлд гарахгүй байх, худалдааны ажилтнууд 2 цаг тутамд гараа угааж ариутгах, лангуу, хаалганы бариулыг ариутгалын бодистой уусмалаар арчих, худалдааны зааланд өдөр бүр ариутгалын бодистой уусмалаар цэвэрлэгээ хийхийг үүрэг өгч ажиллаж байна.

Хяналт шалгалтын үеэр худалдаа эрхлэгчдэд 4 төрлийн 100 гаруй гарын авлагыг тарааж ариутгал халдваргүйтгэл хийх талаар заавар зөвлөмж өгч ажиллалаа.

Хүнс, Хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн хөгжлийн бодлолго зохицуулалтын газарт Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа сүүний үйлдвэр цехийн судалгаа, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамжийн өнөөгийн байдлын мэдээллийг бэлтгэн аймгийн Онцгой комиссын хуралд танилцууллаа.

COVID -19 вирусын тархалттай холбоотойгоор жуулчдын мэдээллийг холбогдох газруудаас авч, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах зорилгоор 2 сарын 26-ны амралтын өдөр ажиллаж 23 сум, 1 тосгоны удирдлага, үйл ажиллагаа явуулж жуулчин хүлээн авсан 4 гэр буудал, 3 жуулчны баазын захиралтай утсаар холбогдож аймгийн хэмжээнд 2020 оны 02 дугаар сарын 10-аас 02 дугаар сарын 24-ны хооронд ирсэн жуулчдын судалгааг нэгтгэн гаргаж БОАЖЯ, аймгийн ЗДТГ, аймгийн тагнуулын газарт хүргүүлэв.

